



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэмээх үндэстний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 14 сарын 14-ны
өдөр хүлээн авсан.

2021 оны 14 сарын 14 өдөр

Дугаар 4731

Улаанбаатар хот

Г Жирамд өөрчлөлт оруулах тухай Г

Монгол улс Нэгдсэн Үндэстний байгууллагын 1961 оны "Мансууруулах эмийн тухай", 1971 оны "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай", 1988 оны "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг" конвенциудад нэгдэн орох тухай "Монгол Улсын хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.3, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын 1 дэх заалтын "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам" гэснийг "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, экспортлох, ханган нийлүүлэх журам" гэж, "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лицензийн загвар" гэснийг "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын лицензийн загвар" гэж, "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лиценз хүсэх өргөдлийн загвар" гэснийг "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын лиценз хүсэх өргөдлийн загвар" гэж, нэгдүгээр хавсралтаар батлагдсан журмын 1.1 дэх хэсгийн "... импорт, үйлдвэрлэл, хангамжтай холбоотой асуудлыг..." гэснийг "... импорт, үйлдвэрлэл, экспорт, хангамжтай холбоотой асуудлыг ..." гэж, 1.2 дахь хэсгийн "... импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэхэд ..." импортлох, үйлдвэрлэх, экспортлох, ханган нийлүүлэхэд ..." гэж, 2 дугаар зүйлийн "... импортох" гэснийг "... импортлох, ханган нийлүүлэхэд ..." гэж, 2 дугаар зүйлийн "... импортох" гэснийг "... импортлох, экспортлох" гэж, 2.1 дэх хэсгийн "... импортын лицензийг ..." гэснийг "... импорт, экспортын лицензийг ..." гэж, 2.2 дахь хэсгийн "... импорт, экспортын лиценз олгоно" гэснийг "... импортлох, экспортлох ..." импорт, экспортын лиценз олгоно" гэж, 2.3, 2.3.4 дэх хэсгийн "импортын лиценз" гэснийг "импорт, экспортын лиценз" гэж, 2.3.2 дахь хэсгийн "экспортлогч ..." гэснийг "экспортлогч, импортлогч ..." гэж, 3.4 дэх хэсгийн "... эм үйлдвэрлэх болон ханган нийлүүлэх ..." гэснийг "... эм үйлдвэрлэх, экспортлох болон ханган нийлүүлэх ..." гэж, 3.4.2 дахь хэсгийн "үйлдвэрлэх, экспортлох болон ханган нийлүүлэх ..." үйлдвэрлэх, экспортлох болон ханган нийлүүлэх

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН

ХУУЛБАР ҮН.

импортлох ..." гэж, 3.4.3 дахь хэсгийн "импортлосон болон үйлдвэрлэсэн ..." гэснийг "импортлосон, экспортлосон болон үйлдвэрлэсэн ..." гэж, 5.8.2, 5.8.3 дахь хэсгийн "импортлосон, үйлдвэрлэсэн ..." гэснийг "импортлосон, үйлдвэрлэсэн болон экспортлосон ..." гэж тус тус өөрчилсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (Б.Цэцэгсайхан)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг), Төрийн захиргааны удирдлагын газар (П.Эрхэмбаяр)-т даалгасугай.

САЙД

C. Ambar

С.ЭНХБОЛД

Handwritten notes in Mongolian script, possibly indicating a date or reference number.